

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг:
oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд тудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/232

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.СОДНОМЦЭРЭН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад

076026958

хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай нийт 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, хугацаа хоцроосон, буруу мэдээлсэн зэрэг алдаа гаргасан байна.

Ебаримт-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 20 ширхэг 32.2 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 7 ширхэг сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Бусад асуудлын хэсэг

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 85.6 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,706,794.69	145,643,269.65
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	36,997,240.29	85,377,398.25
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	36,997,240.29	85,377,398.25
31210	Төгрөг	36,997,240.29	85,377,398.25
31211	Төрийн сангийн харилцах	17,397,640.29	66,010,798.25
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	19,599,600.00	19,366,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,709,554.40	60,265,871.40
35100	Түүхий эд материал	24,609,966.00	27,013,596.00
35110	Тусгай зориулалттай материал	24,472,856.00	26,822,756.00
35130	Эм боох материал	137,110.00	190,840.00
35400	Хангамжийн материал	24,099,588.40	33,252,275.40
35410	Бичиг хэргийн материал	356,600.00	295,100.00
35420	Аж ахуйн материал	18,507,212.40	28,965,175.40
35440	Түлш, шатах тослох материал	260,000.00	190,000.00
35450	Барилгын засварын материал	217,500.00	217,500.00
35460	Хүнсний материал	4,758,276.00	3,584,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	779,175,900.93	748,264,891.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	779,175,900.93	748,264,891.34
39200	Биет хөрөнгө	728,011,234.16	697,188,224.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	746,612,613.95	746,612,613.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,038,032.44	-74,736,090.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	47,899,857.15	47,899,857.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,173,145.61	-34,315,437.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,063,711.00	39,063,711.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,253,865.31	-29,666,703.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,374,508.00	3,374,508.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,880,415.19	-2,450,237.27
39217	Ном	1,406,002.61	1,406,002.61
39300	Биет бус хөрөнгө	51,164,666.77	51,076,666.81
39301	Програм хангамж	827,000.00	827,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-702,333.23	-790,333.19
39303	Бусад биет бус хөрөнгө	51,040,000.00	51,040,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	864,882,695.62	893,908,160.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,576,322.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,576,322.00
41300	Өглөг	0.00	1,576,322.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	371,551.00
41360	Бусад өглөг	0.00	1,204,771.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,204,771.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	864,882,695.62	892,331,838.99
51	Засгийн газрын хувь оролцоо	864,882,695.62	892,331,838.99
51100	Засгийн газрын оруулсан капитал	809,939,582.58	809,939,582.58
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	809,939,582.58	809,939,582.58
51200	Хуримтлагдсан үр дүн	-47,323,561.36	-19,874,417.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-895,413,478.98	-47,323,561.36
51220	Тайлант үеийн үр дүн	848,089,917.62	27,449,143.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,266,674.40	102,266,674.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	864,882,695.62	893,908,160.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,203,129,986.77	458,079,696.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	858,918,410.01	555,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	858,918,410.01	555,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,253,484.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	313,500.00	175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,939,984.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	807,623,760.61	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	48,041,165.40	380,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	344,211,576.76	457,524,296.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298,491,200.00	411,962,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	298,491,200.00	411,962,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,720,376.76	45,562,196.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,720,376.76	45,562,196.78
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	353,965,570.15	430,630,553.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,965,570.15	430,630,553.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,565,570.15	423,765,553.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,942,575.00	276,910,251.00
210101	Үндсэн цалин	177,927,906.00	231,309,320.00
210102	Нэмэгдэл	47,585,267.00	39,619,768.00
210104	Урамшуулал	3,429,402.00	5,981,163.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,095,093.71	35,059,792.04
210201	Тэтгэврийн даатгал	20,117,089.32	24,316,625.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,172.88	2,860,092.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,830,538.25	2,208,853.90
210204	Ажилгүйдлийн даатгал	419,935.51	497,512.69
210205	Эрүүл мэндийн даатгал	4,355,357.75	5,176,707.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,520,095.76	31,562,196.78
210301	Гэрэл, цахилгаан	3,601,546.76	5,267,807.78
210302	Түлш, халаалт	18,759,125.00	20,817,269.00
210303	Цэвэр, бохир ус	5,159,424.00	5,477,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,772,535.00	3,225,937.00
210401	Бичиг хэрэг	958,630.00	643,650.00
210402	Тээвэр, шатахуун	90,000.00	70,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,480.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,688,425.00	2,512,287.00
2105	Нормативт зардал	23,133,146.00	33,916,446.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	294,655.00	59,420.00
210502	Хоол, хүнс	22,838,491.00	33,857,026.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,654,200.00	3,899,600.00
210604	Урсгал засвар	1,654,200.00	3,899,600.00
2107	Томилолт, зочны зардал	145,800.00	0.00
210702	Дотоод албан томилолт	145,800.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	644,900.00	614,625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	564,900.00	614,625.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,657,224.68	38,576,705.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,046,860.00	5,739,696.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	297,020.00	1,926,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,313,344.68	30,911,009.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,000.00	6,865,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	6,865,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	6,865,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	849,164,416.62	27,449,143.37
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,074,499.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,074,499.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	848,089,917.62	27,449,143.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	367,973,654.76	466,021,296.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,893,100.00	8,497,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,893,100.00	8,497,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,893,100.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	313,500.00	175,000.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	22,579,600.00	0.00
120009	Бусад орлого	0.00	8,322,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	345,080,554.76	457,524,296.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298,491,200.00	411,962,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	298,491,200.00	411,962,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	868,978.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	868,978.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,720,376.76	45,562,196.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,720,376.76	45,562,196.78
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	330,976,414.47	417,641,138.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	330,976,414.47	417,641,138.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328,576,414.47	410,776,138.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,598,375.00	284,882,200.00
210101	Үндсэн цалин	192,245,087.00	203,913,062.55
210102	Нэмэгдэл	40,384,986.00	75,389,719.14
210104	Урамшуулал	2,968,302.00	5,579,418.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,095,093.71	35,059,792.04
210201	Тэтгэврийн даатгал	20,125,837.63	23,878,960.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,353,714.52	2,881,932.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,829,251.59	2,279,025.64
210204	Ажилгүйдлийн даатгал	419,563.81	537,161.25
210205	Эрүүл мэндийн даатгал	4,366,726.16	5,482,712.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,520,095.76	31,562,196.78
210301	Гэрэл, цахилгаан	3,601,546.76	5,267,807.78
210302	Түлш, халаалт	18,759,125.00	20,817,269.00
210303	Цэвэр, бохир ус	5,159,424.00	5,477,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	0.00
2105	Нормативт зардал	23,136,500.00	32,683,250.00
210502	Хоол, хүнс	23,136,500.00	32,683,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,799,960.00	14,000,000.00
210604	Урсгал засвар	2,799,960.00	14,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	644,900.00	638,800.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	564,900.00	638,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,281,490.00	11,949,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,281,790.00	10,033,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,999,700.00	1,916,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,000.00	6,865,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	6,865,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	6,865,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,997,240.29	48,380,157.96
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	36,997,240.29	48,380,157.96
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	36,997,240.29
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,997,240.29	85,377,398.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	809,939,582.58	388,282,143.40	-341,687,821.97	856,533,904.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	809,939,582.58	388,282,143.40	-341,687,821.97	856,533,904.01
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	286,015,469.00	-553,725,657.01	839,741,126.01
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	848,089,917.62	848,089,917.62
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,939,582.58	102,266,674.40	-47,323,561.36	864,882,695.62
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	809,939,582.58	102,266,674.40	-47,323,561.36	864,882,695.62
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	809,939,582.58	102,266,674.40	-47,323,561.36	864,882,695.62
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	27,449,143.37	27,449,143.37
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	809,939,582.58	102,266,674.40	-19,874,417.99	892,331,838.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,534,700.00	363,523,942.04	66,010,757.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,534,700.00	363,523,942.04	66,010,757.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429,534,700.00	363,523,942.04	66,010,757.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,842,300.00	284,882,200.00	51,960,100.00
210101	Үндсэн цалин	226,408,700.00	203,913,062.55	22,495,637.45
210102	Нэмэгдэл	102,332,000.00	75,389,719.14	26,942,280.86
210104	Урамшуулал	8,101,600.00	5,579,418.31	2,522,181.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,104,600.00	35,059,792.04	7,044,807.96
210201	Тэтгэврийн даатгал	28,631,300.00	23,878,960.42	4,752,339.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,368,300.00	2,881,932.03	486,367.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,694,600.00	2,279,025.64	415,574.36
210204	Ажилгүйдлийн даатгал	673,800.00	537,161.25	136,638.75
210205	Эрүүл мэндийн даатгал	6,736,600.00	5,482,712.70	1,253,887.30
2105	Нормативт зардал	39,638,700.00	32,683,250.00	6,955,450.00
210502	Хоол, хүнс	39,638,700.00	32,683,250.00	6,955,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	638,800.00	638,800.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	638,800.00	638,800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,310,300.00	10,259,900.00	50,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,393,900.00	8,343,500.00	50,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,916,400.00	1,916,400.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	429,534,700.00	412,137,100.00	17,397,600.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	411,962,100.00	411,962,100.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	411,962,100.00	411,962,100.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,572,600.00	175,000.00	17,397,600.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	175,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	17,397,600.00	0.00	17,397,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	17,397,640.29	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	66,010,798.25	-
				66,010,798.25

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4 зөрчил¹ илэрснээс 106,619.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчлийн 1,576.3 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил байх тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв

5.1 Төлбөрийн акт

2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт1: Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай нийт 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, хугацаа хоцроосон, буруу мэдээлсэн зэрэг алдаа гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж1:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудын дагуу тогтмол, хугацаанд нь үнэн зөв мэдээлж хэвших

Илрүүлэлт 2: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 20 ширхэг 32.2 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 7 ширхэг сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 2: И баримтын дүнг тухай бүрд өөрийн байгууллагын бүртгэлтэй тулгаж бодитоор ажил гүйлгээ гараагүй И баримт гарах тухайн харилцагч байгууллагад мэдэгдэж буцаалтыг баталгаажуулж санхүүгийн бүртгэлдээ үнэн зөв баримтыг тусган ажиллах

Илрүүлэлт 3: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаад 1,2,3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

Өгсөн зөвлөмж 3: Үндсэн хөрөнгийг НБББББ болон УСНБББОУС-17 "Үндсэн хөрөнгө" бүртгэх зааварт нийцүүлэх бүртгэх, холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлэн ажиллах

Илрүүлэлт 4: Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөрийн данс хамгийн өндөр өсөлттэй байсан буюу 1 576 322 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдэлийг тооцсон байх" Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж 3: Тооцооны үлдэгдлийн баталгаагүй авлага, өр төлбөр бүртгэхийг таслан зогсоож, тооцоо нийлсэн актыг тооцооны баримтын жагсаалттай хамт үйлдэж хэвших, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.									
	1		8,322.0					1	8,322.0
ДҮН									
	1							1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Ebanking-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 20 ширхэг 32.2 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 7 ширхэг сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.									
	1		10,355.9					1	10,355.9
ДҮН									
	2		18,677.9					2	18,677.9